

МОНГОЛ УЛС ДАХЬ МОНГОЛ ГҮН УХААНЫ ТҮҮХИЙН
СУДАЛГААНЫ ТУЛГАМДСАН АСУУДЛУУД

Р.Дарьхүү¹

Түлхүүр үг: гүн ухаан, уламжлалт сэтгэлгээ, мөнх тэнгэр, тэнгэризм, мөнх тэнгэрийн ёс зүй.

Энэхүү өгүүлэлдээ бид манай орон дахь монгол гүн ухааны түүхийн судалгааны говч тойм, өнөөгийн судалгааны тулгамдсан асуудлыг авч үзэх зорилго болгов. Учир нь монгол гүн ухааны түүхийн судалгаа бол манай орны иргэдийн оюуны санааны хөгжлийн нэг бүрэлдэхүүн хэсэг бөгөөд монгол судлалын судалгааны нэгэн чухал салбар юм.

Монгол гүн ухааны хөгжил нь манай улсын түүхэн хөгжилтэй ч салшгүй холбоотой. Манай орны хувьд монгол гүн ухааны сургалт, судалгааг өргөжүүлэн гүнзгийрүүлэх нь шинжлэх ухаан-тайин мэдэхүйн болон нийгэм-улс төрийн олон талын ач холбогдолтой зорилт болж байна.

Монгол гүн ухаан бол монголчуудын олон мянган жилийн оюуны бүтээлч эрэл хайгуулын үр дүнд бий болсон өргөн агуулгатай мэдлэг ухаан юм. Монгол гүн ухаан бол өнөөгийн монголчууд бидний өвөг дээдсээс залгамжлан авбал зохих оюуны том соёл мөн.

Эдүгээ монгол гүн ухааны талаарх судлаачын ойлголт олон янз байна. Үүний учир шалтгаан бас олон юм. Гол шалтгаан бол аливаа манай ард түмний гүн ухаан үүсэхээсээ эхлээд олон ургальч үзлийг уралдуулах талбар болж ирсэн явдал юм. Энэ бол монгол гүн ухааны сул тал биш, харин ч түүний давуу тал юм.

Монгол гүн ухаан нь үнэхээр олон талтай, өргөн агуулгатай, баялаг сэтгэлгээ билээ. Монгол гүн ухааны түүх бол монгол хүнийг хүн шиг хүн болгон төлөвшүүлэхэд, ялангуяа монголын хойч ирээдүй болсон хүүхэд, залуучуудыг хөдөлмөрч хичээнгүй, эе эвийг эрхэмлэдэг, идэвх зүтгэлтэй, төлөв даруу, хүмүүнлэг, энэрэнгүй, ухаалаг иргэд болгож төлөвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Ийм ч учраас манай улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдорж 2010 онд “Монголын уламжлалт сэтгэлгээ, арга билгийн ухааны үндэс” хичээлийг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулах тухай зарлиг гаргасан юм. Тэрхүү зарлигт тэмдэглэхдээ: “Монголын оюун сэтгэлгээний өв уламжлалаас суралцах, судлах, хадгалан хамгаалах, сэргээн дэлгэрүүлэх, баяжуулан хөгжүүлэх замаар үндэсний болон нийтийн эрх ашиг, аюулгүй байдал, иргэний эв нэгдэл, хувь хүний итгэл үнэмшил, соёл, үнэт зүйлс, халдашгүй байдлын баталгааг бэхжүүлэх,

1. Монгол Улсын Их Сургууль.

Р.Дарьхүү

Монгол хүн бүрийг бага балчраас нь үндэсний уламжлалт соёл, ёс заншил, зан үйлд сургаж, амьдрал ахуйд нь мөрдлөг болгон хэвшүүлэх ..." хэмээн бичсэн нь монгол гүн ухааны түүхийн судалгааг улам өргөжүүлэх хэрэгтэй байгааг харуулж байна.

Монголын ард түмний бүтээсэн соёлын "хамгийн үнэт сор шим" болох уламжлалт гүн ухааны сэтгэлгээний түүхийг улам гүнзгийрүүлэн нарийвчлан судлах замаар түүний түүхэн болон орчин үеийн ач холбогдлыг тодорхойлж, түүнээс бид сэргээн шинэчлэн суралцах нь манай үндэсний соёлыг хөгжүүлэхэд зайлшгүй хэрэгтэй байна. "Уламжлалгүй шинэчлэл сүйрэл дагуулдаг" гэсэн мэргэн үг байдаг.

Монгол гүн ухааны түүхийн судалгааны нэг тулгамдсан асуудал бол Монгол гүн ухааны түүхийн талаарх судлаачдын үнэлэмж янз бүр байгааг дахин нягталж үзэх, улмаар нэгдсэн нийтлэг зөв ойлголттой болох асуудал юм. Энэ талаар судлаачид зөрөөтэй олон хариулт өгч байна. Тухайлбал: Академич Ч.Жүгдэр: "Философийн сэтгэлгээг дагнан боловсруулж, хөгжүүлж байдаг тусгай заяагдсан сонгомол ард түмэн гэж байдаггүй. Гагцхүү түүхэн хөгжлийн аль шатанд, нийгэм-эдийн засгийн ямар нөхцөлд оршин хөгжиж байгаа зэргээс шалтгаалан ард түмэн бүр хүн төрөлхтний сэтгэлгээний санд өөр өөрийн зохих хувь нэмрийг оруулах замаар философи, нийгэм-улс төрийн сэтгэлгээгээ хөгжүүлж ирсэн түүхтэй, тийм ч жам ёстой"² хэмээн улс үндэстэн болгон өөрийн гүн ухаантай байдаг гэж үзсэн юм. Энэхүү баримтлалтай бид үндсэндээ санал нэг байгаа болно. Учир нь философи бол үндэстэн бүхэн ертөнцийг өөрийнхөөрөө ухаарахуй, ойлгохуй билээ.

Түүний энэ үзлийг шүүмжилж, судлаач Ж.Энхбаяр хэлэхдээ: "ХҮІ зуунд л монголын философи үүсч хөгжих эхлэл тавигдсан"³ гэжээ. Энэ дүгнэлтийн хувьд монгол философи хэмээх ойлголтыг явцуу утгаар арай өрөөсгөл байдлаар хандсан үзэл болно. Монгол гүн ухааныг өрнийн философийн шалгуураар тайлбарлах боломжгүй юм. Өрнө дахины соёл бүхний багш биш гэж би хувьдаа боддог юм.

Монгол гүн ухаан нь юуны өмнө нүүдэлчдийн сэтгэхүйн эрх чөлөөтэй холбоотой нүүдэлчдийн гүн ухаан билээ. Нүүдэлчин малчид нь тариачдаас эдийн засгийн болон иргэний талаар хамаагүй илүү эрх чөлөөтэй байжээ. Үүнийг дагалдан сэтгэлгээний эрх чөлөө хөгжсөн нь 13-р зуунд Монгол улс үндэстэн мандан бадрахын үндэс болсон түүхтэй юм.

Монгол дахь монгол гүн ухааны түүхийн судалгааны ажилд жинтэй хувь нэмэр оруулсан хүн бол манай улсын нэрт эрдэмтэн Ч.Жүгдэр⁴ юм. Тэрээр монгол гүн ухааны сэтгэлгээг нэн эрт үеэс эхлэн ХХ зууны эхэн хүртэлх урт хугацаа, өргөн агуулгаар судалсан байдаг. Академич Ч.Жүгдэр монгол гүн ухааны хөгжлийг эртний монголчуудын ертөнцийг үзэх үзэл, сэтгэлгээ /нэн эртнээс ХІІІ зуун хүртэл/, Монголын нэгдсэн гүрний үеийн нийгэм-улс төр, философи сэтгэлгээний хөгжил /ХІІІ-ХІҮ зуун/, феодализм хөгжсөн үеийн нийгэм-улс төрийн сэтгэлгээ /ХҮ –ХҮШ зуун/, феодализмын уналтын үеийн нийгэм-улс төр, философи сэтгэлгээ /ХІХ-ХХ зуун/ хэмээх үеүдэд ангилсан байна. Түүний бүтээлүүдэд монголчууд гүн ухааны өвөрмөц сэтгэлгээг хөгжүүлж ирсэнийг тайлбарлан, монгол гүн ухааны хөгжлийн эдгээр үе бүрийн онцлогийг тусгайлан судалсан нь монгол гүн ухааны түүхийн орчин үеийн судалгааны үндэс суурийг баттай тавьж өгсөнөөрөө чухал ач холбогдолтой.

2. Ч.Жүгдэр. "Монголын философийн түүхийг судлах арга зүйн зарим асуудал"- Монголын философийн түүхийн зарим асуудал. УБ., 1990. 7 дахь тал

3. Ж.Энхбаяр. Монголын философийн түүх судлалын асуудалд- "Философи, эрх зүйн судлал". ХХҮ боть. УБ., 2010. 32 дахь тал

4. Ч.Жүгдэр. "Развитие философской мысли Монголии в XIX веке". М., 1964.

- "Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ". УБ., 1987.

- "ХҮ –ХҮШ зууны Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм". УБ., 1984.

- "ХІХ-ХХ зууны зааг дахь Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил". УБ., 1972.

Р.Дарьхүү

Эртний монголчуудын ертөнцийг үзэх үзлийн талаар академич Ч.Жүгдэр, академич Г.Лувсанцэрэн, академич Ш.Бира, профессор Д.Дашпүрэв зэрэг олон судлаач өөрсдийн үнэлэлт дүгнэлтээ хийсэн байна.

Эртний монголчуудын ертөнцийг үзэх үзэлд байгалийг танин мэдэх, түүнийг хүнчилж үзэх домгийн болон бөөгийн шашны үзэл, эрхэлж буй мал аж ахуйтайгаа холбогдсон ертөнцийн тухай практик мэдлэг ухаан, давамгайлж байжээ.

Тэр үед хүн ба байгаль, тэдгээрийн үүсэл, хөгжил, амьдралын утга учрын тухай зэрэг өргөн утга агуулга илэрдэг бөгөөд түүнд тэнгэр, газрын шүтэлцээ, түүнд хүний эзлэх байр суурийн тухай тайлбарлах нь гол сэдэв болдог. Гурамсан сэтгэлгээ бол энэ үеийн гүн ухааны нэг онцлог мөн. Үүний тодорхой жишээ бол “ертөнцийн гурав” юм.

Профессор Д.Дашпүрэв өвөг монголчуудын ертөнцийг төсөөлөх байдал болон үзэл санааны талаар тэр үеийн хүмүүсийн үйлдсэн дурсгалт зүйлс, мөн тэдний зан үйлийг илтгэсэн байгууламжуудыг судлах замаар эртний монголчуудын оюун сэтгэлгээний нэг чухал тал болох монгол гүн ухааны тухай “Өвөг монголчуудын угтал философийн үзэл санааны тойм”⁵ өгүүлэл бичсэн буй.

Ийнхүү энэ үеийн монгол гүн ухааны сэтгэлгээ нь манай ард түмний юмс үзэгдлийг байгаагаар нь авч үзэж, зүй ёсыг гол болгож баримталсанаар ертөнцийг сайтар танин мэдсэн саруул ухаан, уужим сэтгэл болон сэтгэхүйн гүн нарийн бясалгагч чанарын илэрхийлэл болдогоороо онцлог юм.

Монголын эзэнт гүрний үеийн гүн ухааны сэтгэлгээ, түүний онцлог

Энэ үеийн гүн ухааны талаар академич Ч.Жүгдэр, академич Г.Лувсанцэрэн, академич Ш.Бира, судлаач Д.Цогтсайхан, доктор М.Золзаяа, доктор Д.Болд-Эрдэнэ зэрэг олон судлаач бүтээл туурвижээ.

Энэ үеийн гүн ухааны сэтгэлгээний үндсэн чиглэл бол эв нэгдлийн үзэл, монголын нэгдсэн гүрэн, түүний тулгар төрийг тогтоон бэхжүүлэх үйл явцыг бүх талаар үндэслэх үзэл санаа байв. Энэ талаар академич Г.Лувсанцэрэн олон улсын монголч эрдэмтдийн их хуралд хэлэлцүүлсэн илтгэлдээ өгүүлэхдээ: “Байгальтай зохицсон аж төрөх ёсны нэг илрэл нь тэнгэр газрын нэгдлийг голчоор баримтлах үзэл, дадал болно.... Түүгээр ч барахгүй байгалийн бүрдэл хэсэг болсон хүн, түүний үйл ажиллагааг ч уг нэгдэлтэй холбон үздэг байв”⁶ хэмээн тодорхойлжээ.

“Монголын Нууц Товчоо” зохиолд манай монголчуудын гүн ухаан нь юуны өмнө нүүдэлчдийн сэтгэхүйн дотоод эрх чөлөөтэй холбоотой бөгөөд ийнхүү сэтгэлгээний эрх чөлөө хөгжсөн нь XIII зууны үед Монгол улс үндэсгэн мандан бадрахын үндэс болсоныг өгүүлжээ.

Энэ үеийн монгол гүн ухааны нэг үзэл бол тэнгэрчлэх үзэл буюу тэнгэрзм юм. Академич Ш.Бирагийн бүтээлүүдэд энэ талаар дэлгэрэнгүй тайлбарласан буй.

“Мөнх тэнгэр” хэмээх ойлголт бол энэ үеийн философийн тулгуур ойлголт юм. Монголын нууц товчоо зохиолд өгүүлэхдээ:

“Үнэмлэхүйн дээд Мөнх хөх тэнгэр

Үнэнийг үнэн болгон заяасан мөнх хөх тэнгэр

Хамгийн дээд Мөнх хөх тэнгэр

5. Д.Дашпүрэв. “Өвөг монголчуудын угтал философийн үзэл санааны тойм” /Нэн эртнээс МЭӨ П зуун/- Философи, эрх зүйн судлал. ХХҮП боть. УБ., 2012. 75-83 дахь тал

6. Г.Лувсанцэрэн. Монголын нийгэм-улс төрийн сэтгэлгээний онцлогоос – Олон улсын монголч эрдэмтдийн ҮП их хурал. 1997.08.12-16.УБ., 1999. 262 дахь тал

Р.Дарьхүү

Хамаг бүгдийг заяасан Мөнх хөх тэнгэр

Хөдлөхийн дээд Мөнх хөх тэнгэр

Хөдлөх бүгдийг заяасан Мөнх хөх тэнгэр” хэмээн бичжээ. Эндээс үзвэл, мөнх хөх тэнгэр бол бүхний оршихуйн үндэс тулгуур юм.

Түүнчлэн “Мөнх хөх тэнгэрээс заяасан суу залиг эдэлж байгаа хаан хүн бол тэнгэрийн хүү юм”. “Хаан хүн гагцхүү тэнгэрийн хүчээр төрийн хэргээ явуулж, гагцхүү Тэнгэрийн таалал, зарлигийг л хэрэгжүүлнэ” гэх зэргээр хүн тэнгэр харилцан их холбоо хамааралтай болох талаар өгүүлжээ. Ийнхүү мөнх хөх тэнгэрийг шүтэх үзэл нь Их Монгол улсыг байгуулах төрийн бодлогынх нь нэг чухал үзэл баримтлал байжээ.

Энэ үеийн монгол гүн ухааны нэг гол бүрэлдэхүүн нь мөнх тэнгэрийн ёс зүй билээ. Энэ чиглэлээр доктор М.Золзаяа өөрийн судалгааны бүтээлүүддээ тодорхой гайлбарласан буй.

“Монголын Нууц Товчоо” зохиолд⁷ “Мөнх тэнгэр оршиж байгаа учраас хүн заавал сайн байх ёстой. Тэр тусмаа хүний сэтгэлийн сайныг чухалчилна. Хэрвээ муу сэтгэл гаргавал тэнгэрт үл таалагдах бөгөөд тэнгэр шийтгэнэ”.

Сайн мууг ялган ухаарах асуудал нь нийгмийн ёс суртахууны нэн чухал асуудлын нэг байдаг билээ. Энэ талаар “Монголын Нууц Товчоо” зохиолд өгүүлэхдээ: “Ахаа, Ахаа бие тэргүүнтэй, Дээл захтай нь сайн”. “Саруул ухаанаас илүү Сайн нөхөр байдаггүй. Мунхаг хилэнгээс илүү Муу дайсан байдаггүй”⁸ гэх зэргээр олонтаа авч үзжээ. Энэ үзэл сургаалын утга агуулгыг өнөөгийн хүүхэд залууст тайлбарлан таниулах нь их ач холбогдолтой байх болно.

Монголчуудын “Эв нэгдлийн гүн ухааны үзэл” нь бидний харилцааг журамлаж, хүн шиг хүн болж төлөвшихөд бидэнд тусалдаг, түүнийг хүлээн авсан хүн бүхний сайн сайхан зан чанарыг нээж өгдөг бөгөөд хувь хүнийг дэмжиж, хамгаалан хүмүүжүүлдэг, бидэнд нэгдэл нягтрал, итгэлийг бий болгодог ач тустай үзэл юм. Алунгоо эх таван хөвүүддээ өгүүлрүүн: “Та таван хөвүүн миний ганц хэвлийгээс төрөв. Та нар тугаарын таван мөс мэт ганц ганцаар болбоос, тэр нэжгээд мөс мэт хэнд ч хялбархан дийлэгдэнэ. Тэр цугласан мөс мэт хамт нэгэн зетэн болвоос, та нар хэнд ч хялбар яахан дийлдэх, та нар”⁹ гэжээ.

“Эв зөийг хичээх үзэл” бол өнөөгийн бидэнд ч хамтран аж төрөх, оршихуйн үнэт зүйл юм. Энэ талаар Чингис хаан хэлэхдээ:

“Элгэн садан дотроо эв найрамдлаа бүү алдая

Уул нурууг алсавч, уг санаагаа нэгтгэж

Мөрөн голыг гатлавч мөн санаагаа нэгтгэж

Мөнх тэнгэрийн хүчинд мөрийн хүч нэмэгдэж явъя”.

“Эв нэгдэлгүй байдлаас болж сүүдрээс өөр нөхөргүй,

сүүлнээс өөр ташуургүй болно”

“Тугаарын Түнхэлэг горхиноо бүхий иргэн их бага,

сайн муу, адаг түрүү үгүй, эн сацуу буй.

Хялбар иргэн буй. Бид тэднийг дагуулья”. Энэ нь улс оронд ёс суртахуунлиг иргэд олон бол тэр бүр амар хялбар бусдад эзлэгдэн хямрахгүй, харин монголчууд өөр хоорондоо эв зөгүй

7. “Монголын Нууц Товчоо”. УБ., 2011.

8. Мөн тэнд

9. Мөн тэнд

Р.Дарьхүү

бол бусдын эрхшээлд орохдоо амархан, хэврэг байх болно гэсэн утгыг илэрхийлж байна.

Тухайн үед үнэнч шударга байх нь хүн нэр төрөө хадгалж, хамгаалах нэг гол шалгуур байжээ. Тухайлбал, “Дайсан явсан хүн алсан, дайсархсанаа дарж, биеэ нууж, үгээ буцах ажгуу. Харин энэ болбоос алсан, дайсархсанаа үл далдлан, үнэн мөнөөр заан хэлэх буюу. Нөхцөлт / нөхөрлөж болох/ хүн буюу. Зургаадай нэрт ажгуу”. “Хамгийн итгэлт, үнэнч шударга ардыг өдөр үзэх нүд, шөнө сонсох чих болгоё”. “Тэд үзсэнээ үл нуун, үнэн үгээ хэлж, мэдсэнээ мэлзэхгүй, сонссон үгээ сонсгодог билээ” гэх зэргээр “Монголын Нууц Товчоо” зохиолд шударга ёсны учир утга, үнэ цэнийг тодорхой өгүүлсэн байна.

Түүнчлэн “Энэ бие хэврэг боловч Эрхэм нэр мөнх шүү... Ариун явбал ашид тустай” хэмээн нэр төрөө эрхэмлэх үзлийн ач тусыг “Монголын Нууц Товчоо” зохиолд тайлбарласан байна. Хүн нэр төргэй амьдрахад андгай тангарагтаа үнэнч байх, хэлсэн үгэндээ эзэн болох нь чухал байжээ. Аливаа хүмүүн бас ёс журмыг дээдлэн, сэтгэл ухаанаа зөв жолоодон явахыг эрхэмлэх ёстой.

Анд нөхрийн ёс нь үе тэнгийнхэн бие биедээ тус нэмэр, хань түшиг болохоос гадна овог, аймаг харгалзахгүй эзнийхээ өмнө үүрэг хүлээж, тангараг тавьсан чөлөөт хүмүүсийн харилцааны сайхан ёс юм. “Монголын Нууц Товчоо” зохиолд өгүүлсэнээр, Чингис хааны “дөрвөн хошууч баатар”, “дөрвөн хүлэг баатар”, “есөн өрлөг”, “шадар цэрэг эрс” зэрэг нь журамт нөхөр, андын ёсыг сахиж, түүний үйлсийг дэмжин, үнэнч гэдгээ: “Хар нүдний цэцгийгээр хаан чамдаа тусалъя, Эргэх нүдний харцаар эзэн чамдаа тусалъя (Шихихутуг)”. Зэлмэ: “Үхэх амиа хайрлахгүй...”, Есөн өрлөгөөс нь Боорчи: “Ачит эзнийхээ амь биеийг хамгаалж, алтан жолоог чинь алдалгүй дагаж явна” гэдгээ, Мухулай: “Дайсныг дарж, олзыг оруулж явъя” гэх зэргээр тангарагладаг. Хүний амьдралд анд нөхрийн ёс хэмээх эрхэм ёс олон талын ач тустай зүйл билээ. Энэ бүхнээс үзэхэд, мөнх тэнгэрийн ёс зүй нь их өргөн агуулгатай баялаг сургаал юм.

Доктор Д.Болд-Эрдэнэ энэ үеийн философиийн онцлогийг тодорхойлон хэлэхдээ: “XIII зууны монголчуудын философи сэтгэлгээний ерөнхий хэв шинж нь бодит үзэгдлийн оршихуйн гүн ухаан буюу натурфилософи, харин гүүнд суурилсан философи үзлийнх нь онол, номлолын суурь үндэс, гол хэлбэр нь тэнгэр шүтлэгийн гүн ухааны үзэл байжээ”¹⁰ гэжээ.

ХҮ–ХҮШ зууны монгол гүн ухааны хөгжил. Энэ үеийн монголын гүн ухааны гол онцлог бол эв нэгдлийн болон тусгаар тогтнолын үзэл юм. Энэ асуудлаар академич Ш.Бира, профессор Цо.Намсрай, доктор Д.Дашжамц, профессор Н.Хавх, судлаач Д.Цогтсайхан нарын судалгааны бүтээл байгаа. Эдгээр бүтээлд “Тэнгэрээс заяат төрсний хувьд хаан хүн тэнгэрийн зарлигийг дагаж, Мөнх хөх тэнгэрийн хүчээр ертөнц дахиныг захирах эрх, үүрэгтэй” хэмээх нийгэм-улс төрийн сэтгэлгээний уламжлалт үзлийн талаар авч үзжээ.

Мөн энэ үе бол монголд буддизм өргөн дэлгэрсэн үе юм. Энэ талаар академич Г.Лувсанцэрэн 1986 онд “Монгол орон дахь буддын философийн хөгжлийн тухайд”¹¹ илтгэлийг Монгол-Зөвлөлтийн буддын судлаачдын хамтарсан симпозиумд хэлэлцүүлсэн байна. Тэрээр энэхүү илтгэлдээ монголын буддын гүн ухааны товч тойм, түүний хөгжлийн үе шат, орчин үеийн буддын судалгааны асуудлуудыг тодорхойлсон байдаг. Мөн доктор М.Гантуяа¹² “Орчин үеийн монгол буддын философи сэтгэлгээний хөгжилт” өгүүлэлдээ: “Монгол дахь буддын философийн сургалт, судалгаа нь бүхэлдээ монголчуудын философи сэтгэлгээний уламжлалыг сэргээн, шинэ мэдээ баримтууд, эх сурвалж зохиолуудыг тодруулан судалгааны эргэлтэд оруулах, утга,

10. Д.Болд-Эрдэнэ, Мөнх тэнгэрийн гүн ухаан ба төр ёс – Эрдмийн ертөнц, № 6 УБ., 2012, 21 дэх тал

11. Г.Лувсанцэрэн, Буддын гүн ухааны онол-түүхийн асуудлаас, УБ., 2008, 193-200 дахь тал

12. М.Гантуяа, Орчин үеийн монголын буддын философи сэтгэлгээний хөгжилт – “Философи, шашин судлал”/308/51/, УБ., 2009, 128 дахь тал

Р.Дарьхүү

агуулга, үзэл санааг нь эдүгээчлэн тайлбарлах, улмаар буддын философиог оюун сэтгэлгээний нэг чухал бүрэлдэхүүн хэсэг болгон хөгжүүлэхэд чиглэж байгааг” тэмдэглэжээ.

XIX-XX зууны монгол гүн ухааны хөгжил. Энэ үеийн гол онцлог бол үндэсний ардчилсан үзлийг хувьсгалт ардчилсан үзэл болгон хувиргаж, улмаар марксист философи сэтгэлгээ манай оронд дэлгэрэн хэрэгжсэн явдал юм. Монгол гүн ухаан дахь энэхүү өөрчлөлт нь Зөвлөлтийн шууд нөлөөллөөр явагдсан бөгөөд манай уламжлалт гүн ухааныг хоцрогдсон үзэл хэмээн үгүйсгэх, хөрөнгөтний үзлийн эсрэг тэмцэх байдлаар явагджээ. Энэ үеийн чухал ололт бол манай оронд шинжлэх ухааны философи сэтгэлгээ төлөвшин бий болсон явдал юм.

XX зууны манай орон дахь философи сэтгэлгээний хөгжлийг судлахад манай томоохон эрдэмтэд анхаарлаа чиглүүлж иржээ. Тухайлбал, академич Г.Лувсанцэрэн, Цо.Намсрай нар 1961 онд “Монгол дахь марксист философийн сэтгэлгээний хөгжилт” өгүүллийг олон улсын хурлын эмхэтгэлд зориулан бичжээ. Мөн академич С.Норовсамбуу¹³ 1972 онд социализмын үеийн монгол дахь философи сэтгэлгээний хөгжлийн асуудлаар “Монгол дахь философийн хөгжил” сэдвээр олон улсын монголч эрдэмтдийн III их хуралд илтгэл хэлэлцүүлсэн байна. Доктор Д.Дашжамц¹⁴ марксизм монголд дэлгэрэн хөгжсөн явц, үр дүнг судлан, “Марксизм-ленинизм монголд дэлгэрэн хөгжсөн нь” бүтээлээ 1974 онд хэвлүүлжээ.

1990 оноос эдүгээ хүртэл манай оронд ардчилсан өөрчлөлтийн үеийн философи төлөвшиж байна. Монгол улсад уламжлалт гүн ухааныхаа өв санг судалж, суралцах, түүнийг орчин үеийн сэтгэхүйн ололтоор баяжуулж хэрэглэх, улмаар үндэсний философи сэтгэлгээний цогц үзэл баримтлалыг боловсруулан баримтлах хандлага бий болж байна. Нөгөө талаас социализмын үеийн өрнөжсөн уламжлалаа барин өрнийн философийг хуулбарлан хэрэглэх хандлага ч хүчтэй байна.

Иймээс монгол гүн ухааны түүхэн хөгжил, баялаг уламжлалыг элдэв үзэл суртлын дарангуйлал, их гүрнүүдийн ил, далд нөлөөлөлгүйгээр судлан, дэлхий дахинд зөв ойлгуулах үүрэг бидэнд оногдож буй. Энэ талаар доктор Д.Дашпүрэв “Монгол ухаан: Эртний Монголын философийн судлалд” бүтээлдээ өгүүлэхдээ: “Одоогийн монголчуудын маань боловсролтой хэсгийн дотор өвөг дээдсийнхээ түүх, соёлыг басамжлах, тэдний бүтээсэн арвин баялаг өв санг мэдэхгүйн эрхээр чамлан дорд үзэх, бусдын түүх соёлын өмнө сөхрөн залбирах, шүүрс алдан сүрдэгсэд ч бас байсаар байна. Мэдээж хэрэг тэдний зарим нь эрдэм боловсролыг амлахдаа хүний газар, гүний нутагт эхлээд, улмаар түүнийхээ эрхшээлээр тэжээж тэтгэсэн орныхоо түүх, соёлын өмнө сүрдэн дарагдаж, өөрийн орноо гадны хүний оюуны нүдээр харахаас өөр аргагүй байдалд орсон нь буй. Түүнчлэн зарим нэг нь бас өвөг дээдсээ муулж, улс орныхоо түүх, соёлыг гутаан доошлуулж байвал чинээлэг хүчирхэг орны ивээлээр мөнгө олох нүхийг олж үзээд, монголчууд бол зэрлэг нүүдэлчид, малаа л маллахас өөр юм мэдэхгүй ... гэх нь буй”¹⁵ гэжээ.

Ийм төөрөгдлийг засч залруулах зорилгоор 1997-2001 онд ШУА-ийн ФСЭХ-ээс эрхлэн гаргасан “Монголын философийн түүх”-ийн 4 боть зохиол гарсан болно. Энэхүү хамтын бүтээлд монгол гүн ухааны түүх судлалын онол-арга зүйн асуудлууд, монгол гүн ухааны үзэл санааны үндсэн чиглэлүүд, томоохон төлөөлөгчдийн үзэл сургаалийг тоймлон авч үзсэн байна.

Өнөө үед манай орны эрдэмтэд, судлаачид дараах үндсэн чиглэлээр монгол гүн ухааны түүхийн судалгаа хийж байна. Үүнд: Монгол гүн ухааны түүхэн эх сурвалж судлал, Эртний

13. С.Норовсамбуу. The development of philosophic thought in the MPR – Академич С.Норовсамбуу. УБ., 2010. 52-58 дахь тал

14. Д.Дашжамц. “Марксизм-ленинизм монголд дэлгэрэн хөгжсөн нь”. УБ., 1974.

15. Д.Дашпүрэв. Философи, социологи, политлоги. УБ., 2009. 5 дахь тал

Р.Дарьхүү

монголчуудын соёл, сэтгэхүй, Монгол ёс зүйн сэтгэлгээ, Монгол буддист философи, логик, Монгол нийгэм-улс төрийн сэтгэлгээ, Монгол гоо сайхны сэтгэлгээний талаарх судалгаа эдгээр болно.

Сурвалж бичиг судлал нь Монгол гүн ухааны түүхийн судалгааны нэг гол хэсэг юм. Монгол гүн ухааны түүхийн эх зохиолуудыг орчуулах, судлах, хэвлэн түгээх талаар судлаачид багагүй зүйл хийсэн байна. ШУА-ийн Философи, Социологи, Эрх Зүйн Хүрээлэнгийн Монгол философийн түүх, шашин судлалын төвд хэрэгжсэн “Монголын философийн түүхийн эх бичиг, сэтгэгчдийн судалгаа” төсөл сурвалж бичиг судлалын ажилд нэлээд ахиц гаргасан байна.

Монгол гүн ухааны түүхийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь монголын ёс зүйн сэтгэлгээний түүх юм. Монгол ёс зүйн сэтгэлгээний түүхийг судлаачид түүхийн сурвалж, аман зохиол, бичгийн уран зохиол, сэтгэгчийн сургаалд тулгуурлан судлаж байна. Энэ чиглэлээр Ч.Жүгдэр, Д.Дагвадорж, Д.Тунгалаг, Б.Галиндэв, Д.Цэрэннадмид нарын олон эрдэмтэн судалгааны бүтээл туурвиж, өөрсдийн үзэл бодол, үндэслэлийг дэвшүүлэн гаргажээ. Тухайлбал, доктор Д.Дашжамц, Р.Дарьхүү, М.Золзаяа нар “Монгол ёс зүйн сэтгэлгээний түүх” суурь судалгааны бүтээлийг 2007 онд хэвлүүлсэн нь сургалт болон судалгааны ач холбогдолтой бүтээл болсон юм. Монгол ёс зүйн түүхийн судалгаа нь монгол хүний ёс суртахууны эрхэмлэлийг танин мэдүүлэхийн зэрэгцээ үндэсний ухамсар төлөвших, ухаалаг зөв амьдрахуйн сургамж болж байна.

Монгол буддист философи, логикийн чиглэлээр манай улсад багагүй судалгаа хийжээ. Энэ талаар академич Г.Лувсанцэрэн, профессор Д.Дагвадорж, Т.Содномдаргиа, Г.Лхагвасүрэн, М.Гантуяа, О.Чимэг, С.Янжинсүрэн, Р.Алтансүх, Б.Ариунзул нарын судлаачдын бүтээл арвин байна. Профессор Ж.Төмөрбаатар¹⁶ өөрийн бүтээлдээ монголын гоо сайхны сэтгэлгээний түүхийн үндсэн үе шат, гол үзэл санаа, үнэлэмж, ойлголт зэргийг авч үзсэн буй.

Монгол гүн ухааны түүхийн судалгааны цаашид анхаарах зүйлс:

Монгол дахь монгол гүн ухааны түүхийн судалгаа тодорхой түвшинд хүрсэн боловч гийм ч хангалттай биш байгаа. Иймд цаашид энэ талаар хийх зүйл их байна. Үүнд:

Монгол гүн ухааны түүхийн суурь болон хавсарга судалгааг шинэ шатанд гаргах, чанаржуулах, үүний тулд энэ чиглэлийн судлаачдын залгамж халааг бэлтгэх, гэднийг чадваржуулах, тогтвортой ажиллуулах асуудал чухал юм.

Монгол гүн ухаантнуудын зохиол, үзэл санаа, үндсэн баримтлалыг тус тусад нь нарийвчлан судалж, монголын гүн ухааны хөгжилд тэдний оруулсан хувь нэмрийг тодорхойлж, бодитойгоор үнэлэх, тэднээс суралцах хэрэгтэй байна.

“Монгол гүн ухааны дээж бичиг” цуврал гаргах нь монгол судлалын сургалт болон судалгааны ажилд ихээхэн ач холбогдолтой юм.

Монгол гүн ухааны түүхийн судалгааны салбарт өөрийн орны болон гадаадын судлаачдын харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтарсан төслийн судалгаа хийх, олон улсын хурал зохион байгуулах, хамтын бүтээл гаргах асуудал чухал байна.

Монгол гүн ухааны түүхийн асуудлаар хийж буй судалгааг улам лавшруулах, судлаачдыг дэмжих дэмжлэг, урамшуулал үзүүлэх асуудлыг шинэ шатанд гаргах шаардлагатай байгаа юм.

Гадаад орны, ялангуяа өрнийн философийг хэт шүтэх үзэл, өрнийн философийг “засамжилсан орчуулгын” философи давамгайлсан өнөөгийн байдал, үнэлэмж, хандлагыг өөрчлөх хэрэгтэй байна.

16. Ж.Төмөрбаатар. “Монголын гоо сайхны сэтгэлгээний түүхэн тойм”. УБ., 2010

Р.Дарьхүү
ДУГНЭЛТ

Монгол гүн ухаан нь монголчуудын ёс суртахуун, хэл, соёл, түүх, улс төр, эдийн засгийн зэрэг олон асуудлыг судлан, шүүн тунгааж, гүнзгийрүүлэн тайлбарласан мэдлэг, ухаан юм. Монголчуудын тэнгэрчлэх үзэл нь тухайн үеийн нэг төрлийн дэлхийчлэлийн үзэл юм. Монгол төр, монголын ард түмэн тэнгэрлэг язгууртай гэсэн үзлийг лавшруулан судлах хэрэгтэй байна.

Манай өвөг дээдсийн ёс зүйн үзэл сургаал нь өнөөгийн монголчуудын хамтран аж төрөх, оршихуйн үнэт зүйл мөн. Бид ёс суртахууны баялаг уламжлалаа танин мэдэх нь хувь хүн, хамт олны зүгээс муу үйлдлээс сэргийлэх, сайн амьдралын төлөө хамтран ажиллах, өнөөгийн нийгэмд аж төрөх нэг гол хүчин зүйл юм. Монгол ёс суртахуун нь хүний бүхий л үйлийн ёс төр, хүмүүс хүн төрхөө танин мэдэх, үнэлж харилцах арга, хүмүүнлэг ёсны захиргаа болдог онцлогийг судлах нь олон талын ач холбогдолтой.

Монгол гүн ухаан бол хүний ёсоор орчноо үзэх, мэдрэх, хүртэн төсөөлөх, эргэцүүлэн бодох, ухаж сэтгэх эрүүл ухаан мөнийг судлууштай байна.

Монгол гүн ухааны түүхийн судалгаа бол монгол судлалын судалгааны нэг шинэ чиглэл хандлага мөн бөгөөд энэ чухал чиглэлд монгол судлалын бүх судлаачид нийтээрээ анхаарлаа хандуулан хамтран ажиллахыг уриалж байгаа болно. Олон салбарын эрдэмтэн судлаачид хүчээ нэгтгэн хамтран иж бүрэн судалгаа хийх нь илүү үр дүнтэй.

Дахин хэлэхэд, энэхүү өгүүллийн гол зорилго нь манай үндэсний оюуны соёлын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох монгол гүн ухааны түүхийн судалгааг монгол судлалын судалгааны нэг шинэ чиглэл болгон хөгжүүлэх асуудлыг дэвшүүлэн тавихад оршино.

Р.Дарьхүү

НОМ ЗҮЙ

- Академич С.Норовсамбуу. УБ., 2010.
- Ш.Бира. Тэнгэризм
- Д.Болд-Эрдэнэ. Мөнх тэнгэрийн гүн ухаан ба төр ёс – Эрдмийн ертөнц. № 6 УБ., 2012.
- Ч.Ган-Өлзий. Нүүдэлчдийн философийн экорелятив шинж чанарын тухай асуудалд - “Эрдмийн ертөнц” сэтгүүл. УБ., 2011/02.
- Д.Дагвадорж. Бурханы шашин. Монгол уламжлал. УБ., 2000
- Д.Дашжамц. Марксизм-ленинизм монголд дэлгэрэн хөгжсөн нь. УБ., 1974
- Д.Дашжамц, Р.Дарьхүү, М.Золзаяа. Монголын ёс зүйн сэтгэлгээний түүх. УБ., 2007
- Д.Дашпүрэв. Философи, социологи, политлоги. УБ., 2009.
- Д.Дашпүрэв. “Өвөг монголчуудын угтал философийн үзэл санааны тойм” /Нэн эртнээс МЭӨ II зуун/- Философи, эрх зүйн судлал. ХХҮII боть. УБ., 2012.
- Ч.Жүгдэр. Развитие философской мысли Монголии в XIX веке. М., 1964.
- Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ., 1987.
- Ч.Жүгдэр. ХҮ–ХҮШ зууны Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм. УБ., 1984.
- Ч.Жүгдэр. XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм-улс төр; философи сэтгэлгээний хөгжил. УБ., 1972.
- Г.Лувсанцэрэн. Буддын гүн ухааны онол-түүхийн асуудлаас. УБ., 2008.
- Монголын философийн түүхийн зарим асуудал. УБ., 1990.
- Монголын философийн түүх. 4 боть. УБ., 1997-2002
- С.Норовсамбуу. The development of philosophic thought in the MPR – Академич С.Норовсамбуу. УБ., 2010.
- Ж.Төмөрбаатар. Монголын гоо сайхны сэтгэлгээний түүхэн тойм. УБ., 2010
- Н.Хавх. Монголын соёл иргэншлийн гүн ухаан. УБ., 1995.
- Н.Хавх. Монголын нийгмийн гүн ухаан. УБ., 2000.
- Ж.Энхбаяр. Монголын философийн түүх судлалын асуудалд- “Философи, эрх зүйн судлал”. ХХҮ боть. УБ., 2010

6. Theme of paper: “Urgent problems of contemporary research of the history Mongolian Philosophy in Mongolia”

Р.Дарьхүү

ABSTRACT

In this paper, we aimed to consider urgent problems of contemporary research of the history Mongolian Philosophy in Mongolia. The reason is that research is the one of important part of the intellectual development of our nation.

Deepening and widening of the research of the history Mongolian Philosophy and education is comprehensively significant in terms of scientific cognition and social and political aspects. A prominent scholar Jugder.Ch¹⁷ had valuably contributed to the study history of Mongolian philosophy. He had researched Mongolian traditional philosophy broadly from the very beginning to early period of the XX century. He studied peculiarities of development of philosophy of these periods respectively, and in his philosophy treatises it is explained that how Mongolians had developed unique philosophy. These treatises of Jugder.Ch are very important as they founded the research on development of Mongolian traditional philosophy well.

Since 1990, the period Mongolian philosophy in democratic transformation is continuing. Now we research our rich heritages of Mongolian traditional philosophy, while enriching and using them for further transformation into contemporary thoughts and for creating national complex ideology of philosophy. On the other hand, Occidentalized tradition of socialist period has been kept and used in our society. Therefore, we are responsible for introducing and inculcating our richness of heritage and traditional philosophy without any extrinsic influence and ideology of the world. Regarding this issue, doctor Dashpurev.D says in his paper "That some intellectuals of Mongolians underestimate their traditional history and culture without having enough knowledge and exalt history and culture of others. It is clear that they are educated in foreign country and overwhelmed with their culture. Also some of them criticize our own ancestors, their history and culture in such a way to seek a patronage of big developed nation. They also say Mongolians know nothing except herd cattle".¹⁸

To mend such delusion, Institute of philosophy and sociology at Mongolian Academy of Sciences published "The History of Mongolian philosophy"¹⁹ in 4 volumes in 1997-2002. These volumes include theoretical and methodological aspects of history research of Mongolian philosophy, basic tendencies and thoughts of chief representatives.

Researchers have done valuable works for primary sources of history of Mongolian philosophy such as translating, researching and publishing. Also Institute of philosophy and sociology at Mongolian Academy of Sciences implemented a project on 'research on source and thinkers of history of Mongolian philosophy' and had achieved certain improvements in the field. One of important part of history of Mongolian philosophy is the history of ethical thinking. The research on history of ethical thinking of Mongolia is based on historical sources, literature and doctrines of thinkers. Professor Dashjamts.D, professor Darikhuu.R and doctor Zolzaya.M published "History of ethical thinking of Mongolia"²⁰ in 2007, which is significant contribution to research and study of ethics.

17. Ч.Жүгдэр. Развитие философской мысли Монголии в XIX веке. М., 1964. Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ., 1987. Ч.Жүгдэр. ХҮ-ХҮШ зууны Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм. УБ., 1984. Ч.Жүгдэр. XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм-улс төр, философийн сэтгэлгээний хөгжил. УБ., 1972.

18 Д.Дашпүрэв. Философи, социологи, политлоги. УБ., 2009. 5 дахь тал

19 Монголын философийн түүх. 4 боть. УБ., 1997-2002

20 Д.Дашжамц, Р.Дарьхүү, М.Золзаяа. Монголын ёс зүйн сэтгэлгээний түүх. УБ., 2007

To study of the history Mongolian Philosophy, our well known scholars had paid more attention. For instance, an academician Norovsambuu.S²¹, professor Khavkh.N²². Research of history of Mongolian Buddhist philosophy and logic creates a realization to veneration, forms national consciousness and proper living. Numerous scholars namely, academician Luvsantseren.G²³, professor Dagvadorj.D²⁴, professor Sodnomdargia.T. professor Lkhagvasuren.G have studied Mongolian Buddhist philosophy and logic. Professor Tumurbaatar J²⁵ had examined the main concepts, values and historical stages of aesthetical thinking of Mongolia.

Urgent problems of contemporary research of history Mongolian philosophy in Mongolia:

-To bring new stage into the history of Mongolian philosophy in terms of theoretical and applied research, therefore, it is necessary to prepare and improve efficiency (skills) of successors.

-Through detailed studies into influential philosophers and their treatises and philosophy, also show the mite of thinkers into philosophical thinking.

-Publishing "An anthology of Mongolian philosophy" is very significant to research work and educational purpose,

-Also there are many issues and works to be considered and done in the research field of study the history of Mongolian philosophy, such as cooperative projects of national and international researchers, to organize international scientific conference, and to publish cooperative publications and researches etc.

- Need to change present situation, tendency and value of overvaluing foreign, especially western philosophy and its translation.

21 Академич С.Норовсамбуу. УБ., 2011

22 Н.Хавх. Монголын нийгмийн гүн ухаан. УБ., 1996

23. Г.Луvsанцэрэн. Буддын гүн ухааны онол-түүхийн асуудлаас. УБ., 2008.

24. Д.Дагвадорж. Бурханы шашин. Монгол уламжлал. УБ., 2000

25. Ж.Төмөрбаатар. "Монголын гоо сайхны сэтгэлгээний түүхэн тойм". УБ., 2010